



ИЛТГЭЛ

**Сэдэв: Түншлэлд суурилсан үйлдвэрлэлийн дадлагыг
чанаржуулах.**

Илтгэгч : Уул уурхайн мэргэжлийн багш Т.Цолмон

ГОВЬСҮМБЭР 2020 ОН

Оршил.

Энэ чиглэлээр 1990 оноос хойш дорвитой судлагдсан бүтээл байхгүй . техник мэргэжлийн сургуулиуд зах зээлийн шуурганд өртөж нэг хэсэг үйл ажиллагаа нь зогсонги байдалд орсон . Мэргэжлийн боловсролын сургуулиуд 2007 оноос шинээр байгуулагдаж эхэлсэн ба барууны боловсролын систем нэвтэрч чадамжид суурилсан сургалтын арга хэрэгсэл нэвтэрсэн ч аж ахуйн нэгжийн өмчийн ялгаанаас амаарч МСҮТ, Коллеж-д суралцагчдын үйлдвэрлэлийн дадлага хийлгэхэд хүндрэлтэй болсон . Бүх шатны боловсролын чанар муу байгаа дээр дооргүй хүлээн зөвшөөрч хэлж ярьдаг шүүмжилдэг болсон . Мэргэжилтэн бэлтгэхэд үйлдвэрлэлийн дадлагын чанарыг сайжруулах түншлэлийн хэлбэрийг сайжруулах зайлшгүй нэн чухал юмаа .

Судалгааны ач холбогдол .

Энэ сэдвийг сонгосон нь сургалтын чанарыг дээшлүүлэхэд гол хүчин зүйл юмаа .

Судалгааны арга .


Төрийн өмчийн том компаниуд Шиввээ-овоо ХК , Багануур ХК , Борөндөр уулын баяжуулах үйлдвэр , Шарын гол ХК –нбы захирал удирдлагууд хүний нөөцийн ажилтануудтай уулзаж үйлдвэрлэлийн дадлага хийлгэх гэрээ хийх талаар хүсэлт тавихад одоогийн МСҮТ, Коллежууд ,бидний эрэлт хэрэгцээг хангах мэргэжлээр сургалт хийхгүй байгаа болохоор дадлага хийлгэх одоогоор тийм боломж алга гэсэн болохоор төрийн өмчийн уул уурхайн компаниудын эрэлт хэрэгцээнд нийцсэн шаардлагатай мэргэжлээр элсэлт авч сургалт явуулбал сургалтын чанарыг дээшлүүлж болно гэсэн дүгнэлтэд хүрлээ .

Илтгэлийн үндсэн хэсэг .

Шиввээ-овоо ХК , Багануур ХК , Борөндөр уулын баяжуулах үйлдвэр , Шарын гол ХК – зэрэг өндөр хүчин чадалтай уурхайнуудад 6000 вольтоор ажилладаг ЭШ- 10/ 70 ЭШ- 15/ 90 ЭШ- 13/ 50 ЭШ- 25/ 90 драглайн алхагч экскаваторууд , , ЭКГ -5А, ЭКГ- 8и , ЭКГ- 10 шууд утгуурт цахилгаан экскаваторууд ажиллаж , 40- 220 тонн- ын хүнд даацын өөрөө буулгагч автомашинууд , өндөр хүчдэлд ажилладаг цахилгаан тоног төхөөрөмжүүд ажилладаг . Дээрхи машин механизмууд дээр ажиллах мэргэжилтэнг бид өнөөдөр сургаж чадахгүй байна. Үүнд л дүгнэлт хийж ажиллаж чадвал өөрсөнд нь хэрэгцээтэй мэргэжилтэнг сургаж байгаа болохоор үйлдвэрлэлийн дадлага чанартай болж мэргэжилтэний сургалтын чанар сайжирна гэж үзэж байна .


ХНХ-ын яамны сайд байхдаа одоо их хурлын гишүүн С.Чинзориг Говь-Алтай МСҮТ –ийн ажилтай танилцаж яваад 148 оюутантай 20 – гаруй мэргэжлээр сургалт хийж байгаатай тааралдаад ийм олон мэргэжлээр чанаргүй сургалт хийж байгааг цаашид энэ салбарын хэмжээнд мэргэшүүлж төрөлжүүлнэ гэж байсан сайд солигдоод одоо зогсонги байдалтай байна . Харин манай сургуулийн хувьд 1000-ны сорилын сангийн хөрөнгөөр уул уурхайн мэргэжилтэн бэлтгэх чиглэлээр байгуулагдсан учраас дээрхи мэргэжлүүдээр сургалт явуулах бэлтгэл хангаад цаашид ажиллахад маш хялбар байх болно.

Төрийн өмчийн том компаниудын эрэлт хэрэгцээнд нийцсэн мэргэжилтэй ажилтан бэлдэхийн тулд дараах ажлуудыг шат дараатай хийж бэлтгэл хангах нь зүйтэй . Энэ ажлыг сургуулийн удирдлага , багш нар хаана хаанаа дэмжиж сэтгэл санаа нэг эв нэгдэлтэй ажиллах ёстой . Дэлхий даяршиж мэдээлэл нээлттэй хөгжлийн хурд эрчимтэй явагдаж байгаа цаг үед бид ч хоцрохгүйн тулд боломжит шинэ арга , шаардлагатай мэргэжлийн зах зээл байвал түүнийг эзлэж санаачлага авах хэрэгтэй . Яагаад гэвэл сургалтын чиглэлийн хувийн компаниуд биднээс түрүүлээд бэлэн байгаа зах зээл тэр боломжийг ашиглах учраас хурдтай ажиллахгүй бол бид хоцорно. Манай багш нар өнөөдрийн хийж байгаа сургалтандаа сэтгэл ханасан амирлангуй тайван байдал хойш чангаана шүү. Ийм тайлбарыг хийж байгаагийн учир бол багш нарт чөлөөт цаг бие дааж боловсрох хөгжин дэвжих боломж их байгаа учраас шинээр уул уурхайн компанид эрэлт хэрэгцээтэй мэргэжлийн хичээл заахад өөрсдийгөө бэлдээрэй гэсэн утгаар ярьж



байна. Хэрвээ бид уул уурхайн компанид эрэлт хэрэгцээнд нийцсэн сургалт зохион байгуулж чадавч уйлдвэрлэлийн дэдлэгийн асуудал өөрөө шийдэгдэх боломжтой болно. Төрийн өмчийн уул уурхайн компани эрэлт хэрэгцээтэй мэргэжилтэн бэлдэхийн тулд дараах ажлуудыг дэс дараатай цаг хугацаа алдлаггүй хийх хэрэгтэй байна. Үүнд:

1. Төрийн өмчийн өндөр хүчин чадалтай уурхайнуудад 6000 вольтоор ажилладаг ЭШ-10/70 ЭШ-15/90 ЭШ-13/50 ЭШ-25/90 драглайн алхагч экскаваторууд, ЭКТ-5А, ЭКТ-8и, ЭКТ-10 шууд утгуурт цахилгаан автомашинууд, өндөр хүчдэлд ажилладаг цахилгаан тоног төхөөрөмжүүд ажиллах мэргэжлийн "Чадамжид сууригласан сургалтын хөтөлбөр" –үүдийг тухайн уурхай дээр ажиллаж байгаа чиглэл чиглэлийн инженерүүд, өндөр мэргэжлийн зөвлөх инженерүүдтэй хамтран боловсруулж, Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээ, мэдээлэл арга зүйн төвөөр батлуулан тусгай зөвшөөрөл авах.
2. Батлах боловсон хүчнийг тэндэр зарлан шалгаруулж, Уул уурхайн яам болон ХНХЯ –ны зөвшөөрсөн багш нарыг авч ажиллуулах. Мөн өөрийн сургууль одоо ажиллаж байгаа багш нарыг зорилтот хөтөлбөрөөр уурхай дээр ажиллуулж дадлагажуулан, онолын багтгал хангуулан багшлуулах арга хэмжээ авах.
3. Өндөр хүчин чадалтай уурхайнуудад 6000 вольтоор ажилладаг ЭШ-10/70 ЭШ-15/90 ЭШ-13/50 ЭШ-25/90 драглайн алхагч экскаваторууд, ЭКТ-5А, ЭКТ-8и, ЭКТ-10 шууд утгуурт цахилгаан экскаваторууд ажиллаж, 40-220 тонн-ын хүнд даацын өөрөө буулгагч автомашинууд, өндөр хүчдэлд ажилладаг цахилгаан тоног төхөөрөмжүүд ажиллах мэргэжлийн сургалтын материал бааз, анги кабинет, үзүүлэн таниулах материалтай болох. Энэ ажлыг хийхэд уул уурхайн салбарт олон жил ажилласан туршлагатай салбартай танигдсан инженерүүдтэй хамтарч ажиллавал илүү үр дүнд хүрнэ гэж үзэж байна.



4. Мэргэжитэнг хүлээн авах эрэлт хэрэгцээ байсан элсэлт нэг гол асуудал болно . Иймд мэргэжлийн чиг баримжаа харицсан ажилтан – уул уурхайн мэргэжлийн болж өгвөл үйлдвэрийн дадлага туршлагатай байвал сургууль болон мэргэжлээ сайн сурталчиж чадна элсэлт нэмэгдэнэ . Өнгөрсөн гашуун туршлагаас хархад сургууль мэргэжлээ сурталчилж чадахгүй Дэлхийн зөн ОУ –ын байгууллагын мэргэжлийн чиг баримжааны лекцийг удирдлага болгож яриад байхаар ЕБС – төгсөж байгаа хүүхдүүд дэлхий дээр байдаг 5000- мэргэжлийн тухай гайхаж байгаад мэргэжил сургуулиа сонгож чадалгүй хоцордог дутагдал давтагдсаар элсэлтийн төлөвлөгөө биелэхгүй, энэ уул уурхайн сургууль мэргэжлээр хүн элсдэггүй юм гэж хоорондоо ярьж суудаг болсон . Энэ асуудлыг амархан шийдэх боломжтой

Хураангуй .

Судалгаа хийсэн үйлдвэрлэлийн дадлага хийхэд хүндрэлтэй байгаа шалтгааныг дээр товч дурьдсан билээ . Төрийн өмчийн том компаниудын хүсэлт дүгнэлтийн албан бичгүүдийг хавсаргав . Энэ бичиг баримтууд - судалгааны гол шалгуур үзүүлэлт нотлох баримт болно.



БАГАНУУР ХК

УУЛ УУРХАЙ, НҮҮРС ОЛБОРЛОЛТЫН

"БАГАНУУР" ХУВЬЦААТ КОМПАНИ

12150 Улаанбаатар хот, Багануур дүүрэг, ш.х-654

Утас (976)-70210114 Факс (976)-70210115

E-mail: bjs@baganyur.kh.mn

2020.04.29 02/412

Танай

**ХӨДӨЛМӨР НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН ЯАМАНД**

Хүсэлт гаргах тухай

Хүчин чадал өндөртэй уурхайнуудад ажиллаж байгаа уул-тээврийн машин, төхөөрөмж /40тн-оос дээш даацтай өөрөө буулгах автосамосвал, 6кВ-оос дээш хүчдэлд ажиллах цахилгаан шууд утгуурт болон драглайн экскаватор/ дээр ажиллах оператор, засварчин сургах сургалтын чанар өнөөгийн шаардлагыг хангахгүй, давтан сургах, дахин дадлагажуулах шаардлага гарч байна.

Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвүүдэд болон политехник коллежуудад уул уурхайн үйлдвэрлэл дээр ажилласан бол онол практикийн мэдлэг, дадлага, туршлагатай багш нар байхгүйгээс бэлтгэсэн мэргэжилтэнүүд нь үйлдвэрлэлийн шаардлага хангаж чадахгүй байна. Иймд манай эрэлт хэрэгцээг хангасан мэргэжлийн ажилтан бэлтгэх сургалт хийж байгаа ямарч МСҮТ, Политехник коллежийн санал санаачлагыг дэмжин мэргэжлийн сургалт болон үйлдвэрлэлийн дадлага явуулахад дэмжлэг үзүүлэн хамтран ажиллах болно.

"Эхний үе шатанд дараах мэргэжлээр :

1. Хүнд даацын өөрөө буулгагч автомашины оператор
2. Цахилгаан экскаваторын туслах машинч
3. Өрмийн туслах машинч тэсэлгээний туслах ажилтан бэлтгэх, сургах ажлыг Хөдөлмөр Нийгмийн хамгааллын Яамны зүгээс дэмжиж өгнө үү.

**ҮЙЛДВЭР ТЕХНОЛОГИ
ЭРХЭЛСЭН ДЭД ЗАХИРАЛ**

Н.БАЗАРСҮРЭН



МОНГОЛРОСЦВЕТМЕТ ТӨҮТ

БОР-ӨНДӨР УУЛЫН

БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭР

23185 Хэнтийн аймар, Бор-Өндөр сум,
Утас/Факс: (976) 7056 7507, И-мэйл: bor-undur@monros.mn

Танай _____

№ 636

2020.05.05

Хүсэлт гаргах тухай

ХӨДӨЛМӨР НИЙГМИЙН
ХАМГААЛАЛЫН ЯАМАНД

Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвүүдэд болон политехникийн коллежуудад уул уурхайн үйлдвэрлэл дээр ажиллаж байсан дадлага туршлагатай багшлах боловсон хүчний хангалт дутагдалтай тухайн сургууль курс төгсөгчид нь үйлдвэрлэлд гарч ирээд ажил үүргийн тодорхойлолтонд тавигдах шаардлагуудыг хангахуйд хүрч ирлээ. Мөн түүнчлэн ажил мэргэжлийн жагсаалтаар батлагдсан нэршил тухайн ажил мэргэжлийн онцлолт тохируулж чадаагүйгээс энэ ажил мэргэжлээр олон жил ажилласан хүмүүс халуун, хүнд, хортой, нөхцөлд хамрагдан тэтгэвэрт хөнгөлөлтэй нөхцлөөр тогтоолгож чадахгүй хохирч байгааг үндэслэн ажлын байрыг дүгнэлт үнэлгээг хийлгүүлэхээр танай яаманд хүсэлт хүргүүлээд байна.

Иймд дараах мэргэжлээр :

1.Өндөр хүчдэлд ажиллах цахилгаанчин

2.Тохируулгын цахилгаанчин

3.Аппаратурын тохируулгын засварчин

4.Кран болон авто ергүүрийн машинч

5.Тэсрэх материал тээвэрлэх эрхтэй жолооч, оператор

6.Баяжуулах үйлдвэрийн тоногтөхөөрөмжийн засварчин

7.Бульдозерын машинч

8.Дизель хөдөлгүүрийн засварчин

9.Автын цахилгаанчин

10.Автомашинны компьютер оношлогоо тохируулгын засварчин

Зэрэг мэргэжлээр ажилтан сургах МСҮТ, Политехник коллеж хувийн сургалтын төвийн санал санаачлагыг дэмжин мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн дадлага авуулахад дэмжлэг үзүүлэн хамтран ажиллах бололцоотой гэж үзэж байна.

Түвшнэлд суурилсан үйлдвэрлэлийн дадлагыг чанаржуулах

Т.Цолмон

Бор-Өндөр УБҮ-т шаардлагатай байгаа ИТА,мэргэжилтэн,ажилчдын судалгаа
болон шинээр сургах ажил,мэргэжлийн жагсаалт

№	Мэргэжил,мэргэшил	Цех	Тоо	Санал
1	Тоног төхөөрөмжийн механикч инженер	Баргилт, БФ	4	Баклавр болон түүнээс дээш зэрэгтэй,мэргэшсэн байх,мэргэшүүлэн сургах
2	Баяжуулалтын инженер	Баргилт, БФ	4	
3	Илчит тэрэгний инженер	Төмөр зам	1	
4	Цахилгааны инженер	БФ	2	
5	Тохиргооны инженер	Тохиргооны хэсэгт	2	
6	Автоматжуулалтын инженер	БФ	1	
7	Замчин	Төмөр зам	1	Сургалтанд хамруулж бэлтгэх
8	Зүтгүүрийн машинч	Төмөр зам	1	
9	Вагон найруулагч	Төмөр зам	1	
10	Өндөр хүчдэлийн цахилгаанчин	Баргилт, БФ	3	
11	Тохируулгын цахилгаанчин	Баргилт	1	
12	Аппаратурын засварчин	АТЦ	1	
13	Кран болон автоөргүүрийн машинч	АТЦ	1	
14	Тэсрэх материал тээвэрлэх эрхтэй жолооч	АТЦ	1	
15	Цахилгаан ба хийн гагнуурчин БФ	БФ		
16	Автоматикийн засварчин	БФ		
17	Т/т засварчин	БФ		
18	Бульдозерын машинч	Баргилт		
19	Дизель засварчин	ЭХЦ		
20	А втоцахилгаан ч и н	АТЦ		

ЗХ-ийн дарга

П.Түвшинбаяр

Танай яамны харьяа уул уурхайн чиглэлийн мэргэжлийн боловсролын сургуулиудад хүнд машин, механизмдын оператор гэсэн ерөнхий мэргэжлээр төгсөгчид өнөөдрийн уул уурхайн практикт хэрэглэгдэж байгаа техник технологи, тоног төхөөрөмжийг эзэмших, ажиллуулах ажил олгогчдын шаардлагыг хараахан хангахгүй байна. Үйлдвэрлэл дээр тодорхой нэршилтэй ажлын байранд авч ажиллуулахад тохирохгүй хүндрэл үүсэж байна. Мөн нэршлээс хамаарсан сургалтын агуулга хөтөлбөр нь тодорхой мэргэжлийн боловсон хүчнийг чанартай бэлтгэж чадахгүй байна. Иймд дараах байдлаар:

- > Цахилгаан экскаваторын оператор
- > Гидро экскаваторын оператор
- > Хүнд даацын өөрөө буулгагч автомашинны оператор
- > Дугуйт ачигчийн оператор
- > Бульдозерын оператор
- > Авто грейдерийн оператор
- > Авто түргэчийн оператор
- > Ермийн машинны оператор
- > Ашигт малтмал боловсруулах үйлдвэрийн {баяжуулах үйлдвэрийн} оператор гэсэн нэршил, мэргэжлээр сургаж мэргэжлийн үнэмлэх олгож ажиллуулах шаардлагатай байна.

Өнөөдрийн байдлаар [политехник коллеж мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвүүдийн төгсөгч байгаа хүмүүс дээрх шаардлагыг хангаж чадахгүй байна.

Танай яамнаас гаргасан үндэсний ажил мэргэжлийн ангиллын тайлбарт "УАМАТ-д зөвхөн хүнд машин механизмын оператор гэсэн ганцхан нэршил байгаа бөгөөд бусад мэргэжлүүдийн нэршил, ажил мэргэжлийн тодорхойлолтууд байхгүй байна.

Хүнд машин механизмын оператор гэж төгссөн боловч зөвхөн гидро экскаватор үзэж судалсан дэдлал хийсэн төгсөгчид гарч байгаа нь "Ил уурхайн аюулгүй ажиллагааны дүрэм" болон бусад хууль, дүрмийн шаардлагатай зөрчилдөж, төрийн өмчийн том хүчин чадлын уурхайнуудад авч ажиллуулах боломжийг хааж байна. Уул уурхайн чиглэлийн политехник коллеж, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвүүд хэрэглээ ихтэй байна.

Хүсэлт гаргах тухай

ХӨДӨЛМӨР НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН ЯАМАНД

ХҮВЬЦААТКОМПАНИ
ШИВЭЭ ОВОО
ШИВЭЭ ОВОО
42020 Савхүүл, Шивээговь сум, Говьсүмбэр аймаг,
Утас/Факс: (976) 7054-6464
2019.10.08 № 1/788
Танай _____
НБЛ № _____
-Т

Учир нь "Шивээ-Овоо" ХК, Барануур" ХК, "Шарын гол" ХК, "Эрдэнэт" УГТээрт 6000 вольтын хүчдэлээр ажилладаг ЭКТ-5А, ЭКТ-4У, ЭКТ-8И, ЭКТ-10И, ЭШ-10/70, ЭШ-15/90, ЭШ-20/90, ЭШ-25/90 зэрэг маркийн цахилгаан экскаваторуудын машин, туслах машинчин нөөц боловсон хүчин хомсдож, өөрсдөө даралдуулан сургаж байгаа нь хүндрэлтэй байна.

Эдгээр уурхайнуудад эрэлт хэрэгцээ ихтэй байгаа цахилгаан экскаваторын машин, туслах машин, хүнд даацын өөрөө буулгагч авто машины оператор, тэсэлгээний ажлын болон өрмийн машины туслах ажилтан бэлтгэх ажилд онцгой анхаарал хандуулж, дээр дурдсан нэршил мэргэжлээр шаардлага хангасан боловсон хүчин бэлтгэх ажлыг хугацаа алдалгүй шийдвэрлэж, бидний ажилд тусалцаа үзүүлнэ үү.

Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвүүд, политехник коллежид захиалан дээрх мэргэжлүүдээр сургах санал удаа дараа тавьсан ч дээрх чиглэлээр үйлдвэрлэл дээр ажилласан онол практикийн мэдлэг, дадлага, туршлагатай багш нар байхгүйгээс сургалт явуулж чадахгүй байна.

Иймд дараах мэргэжлээр:

1. Хүнд даацын өөрөө буулгагч автомашинны оператор

2. Цахилгаан экскаваторын туслах машинч

3. Өрмийн туслах машинч, тэсэлгээний туслах ажилтан бэлтгэх гэсэн аль МСҮТ, Политехник коллеж хувь хувьсгалын сургалтын төвүүдийн санал санаачилгыг дэмжин мэргэжлийн сургалт хийхэд болон үйлдвэрлэлийн дадлага явуулахад дэмжлэг үзүүлэн хамтран ажиллах болно. Дээрх 3 төрлийн мэргэжлээр түр сургалт явуулах зөвшөөрөл олгож, дэмжлэг үзүүлбэл мэргэжлийн ажилтнуудын дутагдаж байгаа эрэлт хэрэгцээ чанарын шаардлагад бодитой тусалцаа болно.

Хүнд даацын өөрөө буулгагч автомашинны оператор

Цахилгаан экскаваторын туслах машинч

Өрмийн туслах машинч, тэсэлгээний туслах ажилтан бэлтгэх сургах ажлыг ХӨДӨЛМӨР НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМНЫ зүгээс дэмжиж өгнө үү.

ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР Г.ГЭРЭЛХҮҮ

Уул уурхайн эрэлт хэрэгцээ шаардлагыг хангасан сургалт хийх учраас үйлдвэрлэлийн дадлагын түншлэл бүрэн шийдэгдэнэ. Ингэснээр энэхүү итгэлийн үндсэн зорилгоо биелүүлж байгаа юмаа.

Түлхүүр үгс:

Үйлдвэрлэлийн дадлагын түншлэл , мэргэжлийн эрэлт хэрэгцээ , дадлагын чанар , сургалтын чанар , чадамжид суурилсан сургалтын хөтөлбөр , сургалтын материаллаг орчин , сургалтын анги кабинет ,

Дүгнэлт

Төрийн Өмчит Хувьцаат компани болон уул уурхайн үйлдвэр ААН байгууллагад эрэлтэд нийцсэн мэргэжилтэнг бэлтгэхэд холбогдох сургалтын байгууллага , харъяа яамын ажлын уялдаа холбоо зайлшгүй шаардлагатай байна . Төрийн Өмчит Хувьцаат компанид шаардлагатай байгаа мэргэжилтэнг бэлтгэх улмаар хамтран ажиллаж , үйлдвэрлэлийн болон төгсөх дадлагыг чанаржуулах явдал юмаа . Түүнчлэн тухайн мэргэжлийн сургалтын хөтөлбөрийг хийхдээ чиглэл чиглэлийн инженерүүдтэй хамтарч хийх хэрэгтэй байна. Ингэж цогц асуудлыг шийдснээр эрэлтэд нийцсэн баялаг бүтээгчдийг бий болгоно.

Ном зүй :

1. Доктор Б.Хэрлэн , доктор Б.Батболд , Магистер С.Сийлэгмаа , Ж.Дэмчигсүрэн , уул уурхайн зөвлөх инженер Ч.Цогтбаатар ”” Монголын уул уурхайн салбарын хүний нөөцийн өнөөгийн төлөв байдал ,” УБ - хот , 2013 он.



УУЛ УУРХАЙН ЖИШИГ СУРГУУЛЬ
ГОВЬСҮМБЭР ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖ

ИЛТГЭЛ

Сэдэв: “Мэргэжлийн багшийн оролцоо үйлдвэрлэлийн
дадлагын үр дүнд нөлөөлөх нь”

Илтгэл бичсэн: Д.Мөнхцэцэг

М.Чулуунцэцэг

ГОВЬСҮМБЭР АЙМАГ
2020 ОН

АГУУЛГА

ОРШИЛ

1. ОНОЛЫН ХЭСЭГ

Сэдэв: “ Мэргэжлийн багшийн оролцоо үйлдвэрлэлийн дадлагын үр дүнд нөлөөлөх нь “

- ✦ Үйлдвэрлэлийн дадлагын тухай ойлголт

2. СУДАЛГААНЫ ХЭСЭГ

- ✦ Судалгааны зорилго
- ✦ Судлах болсон үндэслэл
- ✦ Судалгааны арга
- ✦ Хамрах хүрээ
- ✦ Судалгааны үр дүн
- ✦ Шийдвэрлэх арга зам

3. ДҮГНЭЛТ

4. АШИГЛАСАН МАТЕРИАЛ

ОРШИЛ

Техник технологи хурдацтай хөгжиж буй өнөөгийн нийгэмд үйлдвэрлэлийн дадлагыг үр дүнтэй зохион байгуулахад багш, сурагчид, нийгмийн түншлэгч байгууллагын хамтын үйл ажиллагаа чухал билээ. Нэрт сурагч хүмүүжүүлэгч Я.А.Коменский “Хүүхдийн өдөр бүр уншиж байх цагаан толгой бол багш хүн юм” гэж хэлсэн нь багшийн арга барил, арга ухаан, үр чадвар чухал болохыг харуулж байна. Үүнээс үндэслэн мэргэжлийн багшийн оролцоотойгоор үйлдвэрлэлийн дадлагын үр дүнг сайжруулахад энэхүү судалгааны ажлын зорилго оршино.

1. ОНОЛЫН ХЭСЭГ

СЭДЭВ: “Мэргэжлийн багшийн оролцоо үйлдвэрлэлийн дадлагын үр дүнд нөлөөлөх нь”

Үйлдвэрлэлийн дадлагын тухай ойлголт

Оюутны танхимд эзэмшсэн онолын мэдлэг, чадварыг практик мэдлэг, чадвар, дадлаар баяжуулах зорилгоор аж ахуйн нэгж, байгууллага дээр зохион байгуулах дадлагыг үйлдвэрлэлийн дадлага гэнэ. Энэ төрлийн дадлага нь танилцах эсвэл мэргэшүүлэх зорилготой байна. Мэргэжилтэн хүний хувьд аж ахуйн аль ч салбар чиглэлийн байгууллагад дадлага хийж байгаа учраас тэр орчин нөхцөлдөө зохицож мэргэшлийн дээд түвшинд судалгаа, үнэлгээ, дүгнэлт өгч ажиллахад оюутнууд анхаарлаа төвлөрүүлвэл зохино. Үйлдвэрлэлийн дадлага бол оюутнуудад олж авсан мэргэжлийн мэдлэгээ өргөжүүлж, улам илүү нарийвчлсан арга аргачлалд сурагчид бололцоог олгодог ороо онцлогтой юм. Тухайн мэргэжлийн сурагчдын төлөвлөгөөн дэх мэргэшүүлэх хичээлийн дийлэнхийг оюутан амжилттай судалсны дараа эзэмшиж буй мэргэжлийнх нь чиглэлүүд мэргэшүүлэх, ажлын арга барилд сурагцуулах, мэргэжлийн ёс зүйн хандлага төлөвшүүлэх зорилгоор үйлдвэрлэлийн дадлагыг зохион байгуулна. Энэ тохиолдолд оюутан сурагчдын байгууллагаас томилсон багш, аж ахуйн нэгж байгууллагаас томилсон мэргэжилтний хамтын удирдлагын дор дадлага хийнэ. Дадалага хийх газар нь үг хичээлийн зорилгоос хамааран үйлдвэр, аж ахуйн газар, сурагчт, эрдэм шинжилгээний чиглэл, төрийн ба төрийн бус байгууллага, төсөл, хөтөлбөр болон шинжлэх ухаан, үйлдвэрлэлийн ач холбогдол бүхий байгалийн тогтоц газар, түүх соёлын дурсгалт газар гэх мэт байж болно. Дадалагын явцад

тухайн байгууллагын үйл ажиллагаанаас өөрт холбогдох үйл ажиллагаатай сайтар танилцаж, ажиллалт хийн тэмдэглэл хөтөлж, шаардлагатай ажил үүргийг гүйцэтгэнэ. Байгууллагын дотоод дүрэм, журамд захирагдаж ажиллахын сацуу байгууллагын мэдээллийн нууцыг задруулахгүй байж, баримтыг алдаж үргэдүүлэхээс урьдчилан сэргийлж ажиллана.

Дадлага удирдагчийн эрх, үүрэг

- Дадлага эхлэхээс өмнө дадлагын хөтөлбөр буюу дадлагын зорилго, оюутны эзэмшвэл зохих мэдлэг, чадвар, дадал, гүйцэтгэх ажлын хэмжээ, дадлагын үед баримтлах дэт журам, хээрийн нөхцөлд мөрдөх аюулгүй ажиллагааны заавар болон бусад асуудлыг оюутанд танилцуулж, гарын үсэг зруулсан байна.
- Дадлагыг хөтөлбөрийн дагуу удирдан явуулах, оюутанд зөвлөн туслах (дадлагын хичээлийн хөтөлбөрт дадлагыг удирдах багшийн оюутантай ажиллах ажиллагааг тодорхой тусгах), хяналт тавихын зэрэгцээ оюутан, аж ахуйн нэгж байгууллагаас дадлагыг удирдах мэргэжилтэн нарыг холбож өрөх үүрэг хүлээнэ.
- Ганцаарчилсан дадлага хийж буй оюутантай байнгын харилцаатай байж, шаардлагатай бөгөөд боломжтой бол газар дээр нь дадлагын байдалтай нь танилцаж, зөвлөгөө өгөх зэргээр дадлагын явцад хяналт тавьж ажиллана.
- Хөдөө орон нутгт дадлага удирдах багш тогтоосон маршрутаар явж, томилогчийн хуудсаа орон нутгийн захираганы байгууллагаар бөглүүлсэн байна.
- Хээрийн дадлагын үед дархан цаазтай газарт нэвтрэх, шаардлагад хэмжээгээр ан амьтан агнах, ховор ургамал, шавьжийн цуглуулга болгох, археологийн маллага хийх зэрэгт зохих хууль тогтоомжийн дагуу зөвшөөрөл авсан байна. Мөн хээрийн дадлагын үед байгаль орчныг хамгаалах талаар тусгай төлөвлөгөө боловсруулан, тухайн газрын байгаль орчин хариуцсан мэргэжилтнээр батлуулан ажиглана.
- Тухайн дадлагыг хийхэд холбогдох хууль тогтоомж, дүрэм журмуудаас шаардлагатай заалтуудыг оюутнуудад уншиж танилцуулах буюу түвшрлэн авч танилцуулга багтсан оюутанд хүргэсэн байна.
- Оюутны дадлагын үр дүнд тодорхойлолт, үнэлгээ өгч, тайланг бүрэлдэхүүн сургуулийн захирлын тушаалаар томилогдсон комиссын гишүүдийн хамт хамгаалуулна.
- Дадлагыг хөтөлбөрийн дагуу удирдан явуулах, оюутанд зөвлөн туслах, хяналт тавих,

- Сургуулиас оюутны дадлагаг үлдирдэг байнгын холбоотой байж, оюутны дадлага хийж буй байдлыг талаар харицан зөвшлцөж, үр дүнтэй хамтран ажиллах,
- Оюутны дадлагын үр дүнд тодорхойлолт, үнэлгээ өгөх,
- Дадлага үлдирдсэн мэргэжилтэнд тооцох цаг, цагийг хөлсийг олгох

Оюутны эрх, үүрэг

- Оюутан тухайн дадлагад хамрагдахаас өмнө судалсан байвал зохих хичээлүүдийг амжилттай судалж, шаардлагатай багц цагийг цуглуулсан тохиолдолд дадлага хийнэ.
- Дадлага эхлэхээс өмнө дадлагын хөтөлбөртэй танилцсан байна.
- Дадлагыг хөтөлбөрийн дагуу гүйцэтгэх ба хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө гаргаж, үлдирдэг бэлтгэж, аж ахуйн нэгж байгууллагаас оюутныг үлдирдэхээр томилогдсон мэргэжилтнээр батлуулж, ажиглана.
- Дадлагын явцад тухайн байгууллагын үйл ажиллагаанаас өөрт холбогдох үйл ажиллагаатай сайтар танилцаж, ажиглалт хийн тэмдэглэл хөтөлж, шаардлагатай ажиг үүргийг гүйцэтгэнэ (Дадлагын тэмдэглэл, тооцооны эх материалыг тайланда хавсаргана).
- Оюутан өөрийн сонгосон, тухайн мэргэжлийн холбогдолтой сэдэв/асуудлаар бие даалтын ажиг/төсөл хийж үр дүнт нь бусад оюутныг байлцуулан, үлдирдэг байх үйл ажиллагааг дор хялалцуулна.
- Дадлага хийх явцад өөрийн санаачилгаар дадлагажиж байгаа үйл ажиллагаатай холбоотойгоор хичээлийн хөтөлбөрт заагаагүй ажлуудыг нэмж гүйцэтгэж болно.
- Тухайн мэргэжлийн хөдөлмөрийн харицанд оролцогчдын эрх, үүргийг судалж мэдсэн байна.
- Байгууллагын дотоод дүрэм, журамд захирагдаж ажиллахын сацуу байгууллагын мэдээллийн нууцыг задруулахгүй байж, баримтыг алдаж үргэдүүлэхээс урьдчилан сэргийлж ажиглана. Баримт, материалыг танилцахдаа үлдирдэг буй мэргэжилтнээс болон эрх бүхий албан тушаалтнаас зөвшөөрөл авсан байвал зохино. Мөн баримтыг гадагш авч явах зэргээр байгууллагын ажигд хүндэрл үчруулахгүй байхаас гадна ажиглалттай өс зүйн хэм хэмжээг сахих соёлтой харицана.
- Дадлага хийж буй газартаа сургуулиа сурталчлах, эрдэм дэлгэрүүлэн соёл түгээж, үлгэр жишээч байх ёстой.
- Ганцаарчигдсан дадлага хийж байгаа оюутан дадлагын хугацаанд үлдирдэг буй багштай байнгын холбоотой ажиглана.

2. СУДАЛГААНЫ ХЭСЭГ

Судалгааны зорилго: Үйлдвэрлэлийн дадлагад сөрөөр нөлөөлж буй хүчин зүйлүүдийг судалгааны асуулгын үндсэн дээр тодорхойлж цаашид энэ байдлаас хэрхэн гарч болох арга замыг тодорхойлоход оршино.

Зорилт:

1. Сэдвтэй холбоотой онолын материал цуглуулж, уншиж судлах
2. Судалгааны арга сонгох
3. Асуулга боловсруулах
4. Асуулгын дагуу судалгаа авах
5. Судалгаанд дүн шинжилгээ хийх
6. Үр дүнг тодорхойлох

Судлах болсон үндэслэл: Үйлдвэрлэлийн дадлага хийх байгууллагыг аль болох эртнээс урьдчилан төлөвлөж цаашид дагнан мөргөших, төгсөний дараа ажиглах байгууллага зэргийг тооцсоны үндсэн дээр дадлага хийх байгууллага тодорхойлох нь илүү үр дүнтэй байдаг. Сургуулийн орчинд багшийн бидэнд хандах хандлага нь гаргасан алдаагаа засах боломж олгодог, нэг ёсондоо зөвхөн танд зориулагдсан орчин байдаг бол үйлдвэрлэлийн дадлага хийх орчинд ийм зүйл гэж байдаггүй. Тэнд таны зөв гэж дэмждэг, буруу гэж боддог бүхэн таны бодсоноос өөрөөр байж болно. Танд "Үгүй ээ, ийм байж болохгүй ш дээ" гэж хэлмээр санагдах олон зүйлтэй нүүр тулах шаардлага гарна. Дадлагын эхэнд мэргэжлийн багштай хамтран төлөвлөгөө гарган батлуулаагүйн улмаас дадлагын эцэст хийгдээгүй дутуу ажиглагаа үлдээж, тайлан бичихэд хүндрэл учирдаг. Тиймээс үйлдвэрлэлийн дадлага хийх явцад эхнээс нь удирдамж болон төлөвлөгөөнд заасны дагуу ажлуудыг хийж гүйцэтгэн, холбогдох материалаа цуглуулах, тайлан бичих, дадлагыг үр дүнтэй хийж гүйцэтгэхэд мэргэжлийн багшийн оролцоо чухал учир энэхүү сэдвийг сонгох үндэслэл болсон.

Судалгааны арга: Энэхүү илтгэлийг бичихдээ ажиглалт, харьцуулах, анализ, асуулгын аргуудыг ашиглан бичсэн.

Хамрах хүрээ: Үүл уурхайн жишиг сургууль Товьсумбар Политехник коллежийн техникч, 1 жил, 2,5 жилийн 60 төгсөгчид

7

Суралцагчдаас авах судалгааны асуулга

1. Та үйлдвэрлэлийн дадлага хийх аж ахуй нэгж, байгууллагаа урьдчилан төлөвлөж байсан уу?

А.тийм Б.үгүй

2. Та үйлдвэрлэлийн дадлага хийх газраа хэрхэн сонгосон бэ?

- А. Өөрийн сонгосон байгууллага, аж ахуй нэгж дээр
- Б. Сургалтын алба, аж ахуй нэгж байгууллага, оюутны гурвалсан гэрээ байгуулсанаар
- В. Танил тал, хамаатан садангийн тусламжтайгаар
- Г. Бусад

3. Үйлдвэрлэлийн дадлагын явцад хийх ажлынхаа төлөвлөгөө гаргаж байсан уу?

А. тийм Б. Үгүй

4. Хэрвээ тийм бол хэнтэй хамтран төлөвлөгөөгөө гаргаж байсан бэ?

- А. Дадлагын удирдагч багш / мэргэжлийн багш /
- Б. Дадлагын удирдагч инженер, техникийн ажилтан
- В. Өөрөө
- Г. Ажлын төлөвлөгөө огт гаргаж байгаагүй


5. Та үйлдвэрлэлийн дадлагаа хэдэн хувийн үр дүнтэй хийж гүйцэтгэсэн бэ?

- А. 90-100 хувь
- Б. 70-80 хувь
- В. 50-60 хувь
- Г. 50-аас доош хувь
- Д. Хангалтгүй


Судалгааны асуулгыг графикаар харуулав

1. Та ҮД хийх аж ахуй нэгж, байгууллага урьдчилан төлөвлөж байсан уу?

■ Тийм ■ үгүй



2. Та ҮД хийх газраа хэрхэн сонгосон бэ?




■ Өөрийн сонгосон байгууллага, аж ахуй нэгж дээр

■ Сургалтын алба, аж ахуй нэгж, байгууллага, оюутаны гурвалсан гэрээ байгуулсанаар

■ Танил тал, хамаатан садангийн тусламжтайгаар

■ Бусад


3. Та ҮД-ын явцад хийх ажлынхаа төлөвлөгөөг гаргаж байсан уу?



4. Та ҮД-ын ажлын төлөвлөгөөг хэнтэй хамтран гаргаж байсан бэ?




5. Та ҮД-аа хэдэн хувийн үр дүнтэй хийж гүйцэтгэсэн бэ?




Судалгааны үр дүнг графикаар харуулав

1, 2-р асуулгын харьцуулалт

- Өөрийн сонгосон байгууллага, аж ахуй нэгж дээр
- Сургалтын алба, аж ахуй нэгж, байгууллага, оюутаны гурвалсан гэрээ байгуулсанаар
- Танил тал, хамаатан садангийн тусламжтайгаар
- Бусад



4, 5-р судалгааны асуулгыг харьцуулалт



Шийдвэрлэх арга зам

- + Үйлдвэрлэлийн дадлага хийх аж ахуй нэгж байгууллагатай нийгмийн түншлэл, мэргэжлийн багш, оюутан 3 хамтран судалж 1- 2 сарын өмнө төлөвлөх
 - + Үйлдвэрлэлийн дадлагын явцад мэргэжлийн багштай хамтран дадлагын удирдамжын дагуу хийх ажлын хуваарь үүрэг даалгаварыг нарийвчлан тодорхойлох
 - + Мэргэжлийн багш үйлдвэрлэлийн дадлагын явцыг биеэр очиж шалгах, зөвлөгөө өгч дадлагын явцад хяналт тавьж ажиллах
 - + Үйлдвэрлэлийн дадлага удирдсан мэргэжлийн багшид цагийн хөлс олгох
- Жишээлбэл:
- а) Мэргэшүүлэх зорилготой үйлдвэрлэлийн дадлагын 1-5 оюутныг удирдахад 7 хоногт оюутан бүрийн 3 цаг, 5-аас дээш оюутан бүрд 1 цаг тооцно.
 - б) Танилцах зорилготой үйлдвэрлэлийн дадлагын 1-5 оюутныг удирдахад 7 хоногт 8 цаг, 5-аас дээш оюутан бүрд 0.5 цаг тооцно.
- + Дээр дурьдсан арга замуудыг хэрэгжүүлсэнээр үйлдвэрлэлийн дадлагын үр дүн бодитоор сайжирна гэж үзэж байна.

ДҮГНЭЛТ

Батшийн эрхэм дээд зорилт нь шавьдаа эрдэм мэдлэг, мэргэжлийн ур чадвар, зөв хандлагыг эзэмшүүлэхэд оршино. Бидний судалгаа нь мэргэжлийн багшийн үйлдвэрлэлийн дадлагын оролцоог шүүмжлэхийг урьтал болгосонгүй.

Үйлдвэрлэлийн дадлагын чанарыг сайжруулахад хамгийн чухал арга зам бол оюутанд зөвлөн туслыхын зэрэгцээ мэргэжлийн багшийн төлөвлөгөөт хяналтан доор үйлдвэрлэлийн дадлага хийх явдал гэж үзэж байгаа юм.

Үйлдвэрлэлийн дадлагыг мэргэжлийн багштай хамт хийлгэснээр тухайн багш үйлдвэрлэлийн дэвшилтэт тоног төхөөрөмжтэй танилцаж мэдлэг мэдээллээ сайжруулах боломж бүрдэнэ. “Мэргэжлийн багшийн оролцоо үйлдвэрлэлийн дадлагын үр дүнд нөлөөлөх нь” илтгэлийн сэдэв маань тасралтгүй судлагдаж, өөрчлөгдөн шинэчлэгдэж байх учиртай.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- ❖ МУИС-ын оюутны дадлагын журам 2011
- ❖ ГСА ПТК-ын дадлагын удирдамж 2020
- ❖ МУИС-ын хичээлийн хөтөлбөр 2018
- ❖ Монгол Коосан коллежийн дадлагын удирдамж 2019
- ❖ Мэргэжлийн болон техникийн боловсролыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр 2016-2021 он
- ❖ Misp.gov.mn
- ❖ Word Press.com
- ❖ lawyerlike.net
- ❖ slideshare.net
- ❖ academia.edu
- ❖ prezi.com
- ❖ MALS.MN